



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/677

Булган сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.5, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 53 дугаар зүйлийн 531, 532, 8 дугаар зүйлийн 8.1.2 дугаар заалт, Барилга хот байгуулалтын сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 199, А/117 тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Булган аймгийн хэмжээнд барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах, техник технологийн аюулгүй байдал, учирч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах зорилгоор “Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” аяныг 2023 оны 09 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 01-ний хооронд Барилга хот байгуулалтын сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд нарын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 199, А/117 тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулсугай.

2. “Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” аяныг зохион байгуулж, хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажлын хэсгийн гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэ аяныг заасан хугацаанд үр дүнтэй хамтран зохион байгуулж тухай бүрд үр дүнг танилцуулан, тайлан мэдээллийг гаргаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Н.Батжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны
09 дүгээр сарын 25-ны өдрийн А/688 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн ахлагч: Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын дарга, Улсын ахлах
байцаагч)
- Ажлын хэсгийн дэд ахлагч: Н.Батжаргал (Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний газрын дарга, Улсын ахлах
байцаагч)
- Гишүүд:
- Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын
хэлтсийн дарга)
 - Б.Ганчулуун (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн)
 - Ж.Хосбаяр (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын
хэлтсийн Барилгын материалын асуудал
хариуцсан мэргэжилтэн)
 - Г.Батцагаан (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын
хэлтсийн дэд бүтцийн асуудал хариуцсан
мэргэжилтэн)
 - Б.Батболд (Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын
улсын байцаагч)
 - Б.Солонго (Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний газрын Хөдөлмөрийн эрүүл ахуйн
хяналтын улсын байцаагч)
 - У.Пунсалдулам (Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын
улсын байцаагч)
- Нарийн бичгийн дарга: Н.Очирхуяг (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын
хэлтсийн Барилгын техникийн хяналтын
улсын байцаагч)



“БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЧАНАР, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ” АЯНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ БУЛГАН АЙМАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Төсөв	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
1	2	3	4	5	6
Нэг. Зохион байгуулалтын ажлын хүрээнд					
1.1	Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” аяныг зохион байгуулах ажлын хэсгийн, төлөвлөгөөг батлуулах	2023.09.12		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ
1.2	Аяны талаар барилгын ажил эрхэлж байгаа АА-нэгжүүдэд мэдээлэл хүргүүлэх	2023.09.15		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ
1.3	Холбогдох шатны удирдлагуудыг аяны мэдээллээр хангаж байх	Тухай бүр		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ
1.4	Аяны хэрэгжилтийн байдлын талаар тайлан гаргаж цаашид анхаарах ажлын талаар санал боловсруулах	2023.10.01, 2023.11.01, 2023.11.20		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ
Хоёр. Зөвлөмж, постер, контент гарын авлага боловсруулах ажлын хүрээнд,					
2.1	Хяналт шалгалтын дүнгээр бусад компаниудад анхааруулах зорилгоор цахим групп үүсгэх	Аяны хүрээнд		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ
2.2	Тодорхой арга хэмжээг үр ашигтай хэрэгжүүлж байгаа компанийн туршлагыг аймгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлэх	Аяны хүрээнд		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ
Гурав. Урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах ажлын хүрээнд					
3.1	Барилгын ажил гүйцэтгэж байгаа компаниудыг сургалтад бүсчлэн хамруулах	2023.10.12-14		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ Барилгын холбоо, ХЭМАБО Сургалтын төв
3.2	ОУХБ-ын Барилгын салбар дахь хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн 167-р конвенцийн хэрэгжилтийг хангуулж сурталчлах	Аяны хугацаанд		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ
Дөрөв. Урьдчилан сэргийлэх хяналт шалтгалтын ажлын хүрээнд					

4.1	Аяны удирдамжийн хүрээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт явуулах	2023.09.14-2023.11.15		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ
4.2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийг хангах чиглэлээр барилга байгууламжид үзлэг хийх	2023.09.14-2023.11.15		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ
4.3	Барилга замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS0301B:2022 стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр үзлэг хийх	Аяны хүрээнд		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ
4.4	БХБ-ын сайдын “Барилга байгууламжийн угсралт, чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулж, ажиллах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 09 сарын 07-ны өдрийн 2021/01 дугаартай албан даалгаврын биелэлтийг хангуулах чиглэлээр хяналтыг явуулах	Аяны хүрээнд		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ
4.5	Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын ерөнхий байцаагчийн 2023 оны 07/01, 07/02 дугаартай албан даалгавруудын биелэлтийг хангуулах	Аяны хүрээнд		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ
4.6	Барилгын ажил явуулж буй АА-н нэгжийн судалгааг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны чиглэлээр явуулах	Аяны хүрээнд		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ
4.7	Барилгын ажил явуулж буй АА-н нэгжүүдийн дотоод хяналтанд эзэд, ТББ-ын ороцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах	Аяны хүрээнд		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ
4.8	Барилгын ажилтнуудын даатгалын байдлыг шалгах	Аяны хүрээнд		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ
4.9	Барилгын захиалагч гүйцэтгэгч нартай хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар хариуцлагын гэрээ байгуулах	Аяны хүрээнд		ГХБХБГ, ХХҮГ	ХБТХОХ, НБХ